

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Булган АЗЗА” ТӨХК-ий 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/02/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: Erdeneb@auditgov.mn Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn
---	---

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4.АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
Үүнээс өмнөх оны зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй, тайлант онд давтан гаргасан зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НББ	Нягтлан бодох бүртгэл,
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.03.15 № 321
танай _____ ны № _____ т

БУЛГАН АЗЗА ТӨХК-ИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Э.ПҮРЭВДЭМБЭРЭЛ ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Булган АЗЗА" ТӨХК-ий оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас "Булган АЗЗА" ТӨХК-ий 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 560,655.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 529,382.4 мянган төгрөгөөр давсан ба материаллаг алдаа, зөрчил нь тархалттай тул "Сөрөг" дүгнэлт өглөө. Үүнд:

- Тайлан хугацаанд нийт 1,350.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалинг суутгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 26 дугаар зүйлийн 26.1, НББ-ийн тухай хуулийн 20.2.5, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй;
- Тайлант онд ТУЗ-өөр нийт 73,530.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэлд зарцуулах зардал батлуулсан ч тендер зарлаагүй, шууд худалдан авалт хийсэн, 980 км замын тэмдэг тэмдэглэгээ, будгийн ажлыг гүйцэтгэх тендер зарлаагүй шууд гэрээ байгуулсан нь ТӨХБАҮХАТХ-ийн 10.2, 10.12, 31.1, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж

мэдэгдлийг хангаагүй;

- Анхан шатны баримтгүй буюу ажил гүйцэтгэх, бараа нийлүүлэх гэрээ байхгүйгээр иргэн Гэрэлтуяа руу 35,000.0 /2023 онд /, иргэн Ж.Бадрах руу 22,000.0 /2022/ мянган төгрөгийг шилжүүлэн авлага үүсгэж Гэрэлтуяа нь 2024 оны 3 сард 25,000.0 мянган төгрөгийг буцаан төлсөн, Бадрахын гэрээг 2023 онд нөхөж гэрээ байгуулан битум нийлүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хангаагүй;
- Иргэн Х.Уламбаяртай 1 тн асфальт зуурах хөлсийг 19,000.0 мянган төгрөг буюу нийт 26,600.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулж гүйцэтгэлээр 971 тн хийсэн байхад санхүүжилтийг гүйцэтгэлээр тооцоогүй 26,600.0 мянган төгрөгөөр тооцоо хийж 7,351.0 мянган төгрөгийг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Инженер Нямдаваад заводын моторын үнэ гэх 4,000.0 мянган төгрөгийг шилжүүлж авлага үүсгэсэн боловч, моторыг орлогод аваагүй өглөг үүсгэж хаасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй;
- Иргэн Х.Уламбаяр луу 4,000.0 мянган төгрөгөөр 2 удаагийн нийт 8,000.0 төгрөгийн заводын тенийн үнэ шилжүүлэхдээ гэрээ байгуулаагүй анхан шатны баримтгүйгээр гүйлгээ хийсэн, тухайн хөрөнгийг хүлээн авсан гэх тайлбар өгөх боловч НӨАТ-гүй, санхүүгийн тайланд орлогоор аваагүй, тооллогоор бүртгэлээс гадуурх хөрөнгөөр тоологдоогүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4, НӨАТХ-ийн 17.3, санхүүгийн тайлангийн аудитын тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй;
- Иргэн Алтанхуяг руу маслоны үнэ гэж 4,000.0 мянган төгрөг шилжүүлж авлагаар бүртгэсэн боловч тухайн гүйлгээтэй холбоотой анхан шатны баримт байхгүй буюу байгуулсан гэрээ НӨАТ-ын баримтгүйгээр гүйлгээ хийсэн, мөн тайланд орлогоор аваагүй, жилийн эцэст тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4, НӨАТХ-ийн 17.3, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй;
- Захирал албан бус хэрэгцээнд 105.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4, Төсвийн тухай хуулийн 16.5.5, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Инженер Мөнх-Эрдэнэ анхан шатны баримтгүйгээр 180,0 мянган төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Нийт борлуулалтын орлогыг 65,891.3 мянган төгрөгөөр илүү тооцоолон татварын өмнөх ашгийг нэмэгдүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1, санхүүгийн тайлангийн аудитын тасалбар болголт, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй;
- Анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй;

- Техникийн комисс, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүйгээр автомашины сэлбэг худалдан авдаг бөгөөд тайланд онд худалдан авсан сэлбэг хэрэгслээс хэрэглэгдээгүй сэлбэгийн үлдэгдэл нь 36.8 хувь буюу 30,764.0 мянган төгрөг байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Тайлант онд шинээр үүссэн авлага, өглөгийн эцсийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант онд давтан гаргасан байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд асфальт заводын үйлдвэрлэл явуулж нийт 971 тонн асфальт бетон зуурмаг үйлдвэрлэж өөрийн хариуцсан чиглэлийн замуудын нөхөөс болон гүүрний суурьтад ашиглаж, иргэн аж ахуй нэгж байгууллагуудад зарж борлуулсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Нийт зардалд 1,929,550.0 мянган төгрөг төлөвлөсөн бөгөөд 1,565,135.4 мянган төгрөгийг зарцуулсан, төлөвлөгөө 81.1 хувийн гүйцэтгэлтэй, үүнээс удирдлагын зардал 334,099.3 мянган төгрөг төлөвлөснөөс 292,064.2 мянган төгрөгийн зарцуулалттай, гүйцэтгэл 87.5 хувь буюу 7,764.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

2023 оны зорилтод түвшнээр 1,950,000.0 мянган төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөсөн ба Зам тээврийн хөгжлийн яамтай байгуулсан гэрээний дагуу замын сангийн хөрөнгөөр зам засвар арчлалтын ажлыг 1,650,000.00 мянган төгрөгөөр, бусад орлогоор 300,000.0 мянган төгрөгөөр бүрдүүлэх төлөвлөгөөг баталсан ба үүнээс Зам тээврийн хөгжлийн яамнаас 1,350,697.8 мянган төгрөг, орон нутгаас 223,064.2 мянган төгрөгийн ажил хийж нийт орлого 80.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлтийн нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.ХӨРӨНГӨ	1,960,767,410.89	1,887,341,284.07
1.1.Эргэлтийн хөрөнгө	784,001,506.36	744,160,678.31
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,203,390.96	2,323,910.20
1.1.2. Дансны авлага	569,485,053.48	362,184,069.75
1.1.3. Бусад авлага	2,087,624.43	66,013.28
1.1.4.Бараа материал	206,225,437.49	379,586,685.08
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	784,001,506.36	744,160,678.31
1.2.1 Үндсэн хөрөнгө	873,645,904.53	840,060,605.76
1.2.2 Биет бус хөрөнгө	303,120,000.00	303,120,000.00
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,176,765,904.53	1,143,180,605.76
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,960,767,410.89	1,887,341,284.06
2.1 Өр төлбөр	890,949,593.98	1,011,550,358.73
2.1.1 Богино хугацаат өр төлбөр	325,738,281.98	446,339,046.73
2.1.1.1 Дансны өглөг	165,411,961.30	284,860,568.53
2.1.1.2 Цалингийн өглөг	15,495,233.38	16,127.74
2.1.1.3 Татварын өр	100,260,540.72	115,209,557.03
2.1.1.4 НДШ-ийн өр	44,570,546.57	46,252,793.42
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	325,738,281.98	446,339,046.73
2.1.2.1 Бусад урт хугацаат өр төлбөр	565,211,312.00	565,211,312.00
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	565,211,312.00	565,211,312.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	890,949,593.98	1,011,550,358.73
2.3 Эздийн өмч	1,098,247,184.14	1,098,247,184.14
2.3.1 Төрийн	1,098,247,184.14	1,098,247,184.14
2.3.2 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	752,128,121.46	752,128,121.46
2.3.3 Хуримтлагдсан ашиг	-780,557,488.69	-974,584,380.27
2.3.4 Эздийн өмчийн дүн	1,069,817,816.91	875,790,925.33
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,960,767,410.88	1,887,341,284.06

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	1,904,360,105.00	1,547,193,951.81
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,911,279,296.31	1,248,783,355.11
3. Нийт ашиг (алдагдал)	(6,919,191.31)	298,410,596.70
4. Бусад орлого	1,901,127.99	26,568,625.54
5. Борлуулалт, маркетингийн зардал	173,621,099.46	231,104,074.89
6. Ерөнхий ба удирдлагын зардал	24,024,483.78	11,455,212.06
7. Санхүүгийн зардал	39,700.00	3,739,484.85
8. Бусад зардал	60,108,572.82	70,053,268.02
9. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(262,811,919.39)	8,627,182.43
10. Орлогын татварын зардал		862,719.00
11. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(262,811,919.39)	7,764,463.43
12. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(262,811,919.39)	7,764,463.43

13. Бусад дэлгэрэнгүй орлого		
14. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(262,811,919.39)	7,764,463.43
15. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,098,247,184.14	752,128,121.46	-780,557,488.69	1,069,817,816.91
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			7,764,463.43	7,764,463.43
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	2024 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,098,247,184.14	752,128,121.46	-974,584,380.27	875,790,925.33

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,898,971,896.11	1,776,528,313.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	125,421,599.00	
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	996,436.40	
Бусад мөнгөн орлого	1,772,553,860.71	1,776,528,313.00
1.2 Мөнгөн зарлагын дүн	2,031,571,412.82	1,780,407,793.76
Ажиллагчдад төлсөн	352,104,916.70	415,515,403.80
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	77,978,871.83	135,012,120.00
Бараа материал худалдан авахад төлсөн	923,986,869.17	589,808,334.02
Ашиглалтын зардал төлсөн	711,790.29	5,500.00
Татварын байгууллагад төлсөн	49,864,033.45	129,938,607.27
Даатгалын төлбөрт төлсөн		108,000.00
Бусад мөнгөн зарлага	626,924,931.38	510,019,828.67

1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(132,599,516.71)	(3,879,480.76)
2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
3.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(9,974,470.00)	
Мөнгөн зарлагын дүн	9,974,470.00	
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	5,885,635.00	
Төлсөн ногдол ашиг	4,088,835.00	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(142,573,986.71)	(3,879,480.76)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(142,573,986.71)	(3,879,480.76)
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	142,891,742.67	6,203,390.96
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,203,390.96	2,323,910.20

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2023 он		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувиар	Дүнгээр
1	Нийт орлого	1,950,000.0	1,573,762.0	80.7	(376,238.02)
	Үүнээс: Улсын чанартай ЗЗА	1,650,000.0	1,350,697.8	81.9	(299,302.22)
	Бусад	300,000.0	223,064.2	74.4	(76,935.80)
2	Нийт зардал	1,929,550.0	1,565,135.4	81.1	(364,414.55)
	Үүнээс:Удирдлагын зардал	334,099.3	292,495.6	87.5	(41,603.69)
3	Татварын өмнөх ашиг	20,450.0	8,626.6	42.2	(11,823.47)
4	Цэвэр ашиг/ алдагдал/	18,405.0	7,763.9	42.2	(10,641.12)
5	Төрийн өмчийн ноогдол ашиг	4,900	-	-	(4,900.00)
6	Ажиллагсдын тоо	45	32.0	71.1	(13.00)
7	Цалингийн сан	536,394.0	543,435.9	101.3	7,041.88
8	Нэг ажилтны дундаж цалин	993.3	1,415.2	142.5	421.88
9	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	0.990	0.995	100.5	0.01
10	Хөрөнгө оруулалт	85,000.0		-	(85,000.00)
11	Нийт авлага	180,000.0	362,118.1	201.2	182,118.10
12	Нийт өглөг	685,211.3	1,010,221.8	147.4	325,010.50
	Үүнээс: Богино хугацаат	120,000.0	445,010.5	370.8	325,010.50
	Урт хугацаат өглөг	565,211.3	565,211.3	100.0	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Булган АЗЗА” ТӨХК нь “Олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто зам, төмөр бетон гүүр хоолойн засвар арчлалтын ажлыг хариуцан авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг байнга ханган ажиллахыг эрхэмлэх” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг авто зам, зам байгууламжийг барих, засварлах гэж тодорхойлсон, улсын бүртгэлийн гэрчилгээнд “хувьцаат компани” гэж бүртгэсэн бөгөөд өмчийн 100 хувийг төр эзэмшдэг төрийн өмчит хувьцаат компани байна.

“Булган АЗЗА” ТӨХК нь 204,1км асфальт бетон хучилттай зам, 38,76км хайрган хучилттай зам, 145,64км ердийн болон сайжруулсан хөрсөн зам бүгд 388,5км Олон улсын болон улсын чанартай замын бэлэнбайдлыг хариуцсан ажилладаг.Үүнд: А0901 дугаартай Булган-Дашинчилэн чиглэлийн 71,5 м, А0902 дугаартай Булган-Мөрөн чиглэлийн 158 км, А1002 дугаартай Эрдэнэт-Булган чиглэлийн 24,1 км, А13 дугаартай Хутаг-Өндөр-Тэшиг-Улсын хил чиглэлийн 134,9 км зам хариуцдагаас гадна Эгийн гүүр, Гуртын гүүр, Орхоны гүүр, орон нутгийн чанартай Хялганатын болон Хануйн гүүрүүд багтдаг байна.

2023 онд 31 орон тоотой, үйлдвэрлэл явуулах 15 тээврийн хэрэгсэл, 21 механизм, 27 техник тоног төхөөрөмжтэй Зам засварлах, барих нөхцөлийг бүрдүүлэн ЗТХЯ-тай байгуулсан гэрээний дагуу хариуцсан Олон улсын болон улсын чиглэлийн замын засвар арчлалтын ажлыг хийж гүйцэтгэхийн зэрэгцээ асфальт заводын үйлдвэрлэл явуулж нийт 971 тонн асфальт зуурмаг үйлдвэрлэж өөрийн хариуцсан чиглэлийн замуудын нөхөөс болон гүүрний суултад ашиглаж, иргэн аж ахуй нэгж байгууллагуудад зарж борлуулсан байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь заалтуудтай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 9 хүнтэй томилсон байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Тус байгууллага Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, бусад хууль, журам, заавруудын дагуу мөрдлөг болгон ажиллаж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь заалтуудтай нийцэж байна. Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 9 хүнтэй томилсон байна. “Булган АЗЗА” ТӨХК-ий Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 233.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн

этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн үед мөрдөгдөж байсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байсан хэдий ч 2019-2021 онд шинэчлэгдсэн хууль, журам, стандартын өөрчлөлтийг тусгаж шинэчлээгүй байна.

Тус компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны 1-р сарын 26-ны өдрийн А/04 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтын комисс байгуулсан байна.

Тайлант онд дотоод хяналт шалгалтын 4 ажил төлөвлөж, төлөвлөгөөт бус 1 ажил төлөвлөж гүйцэтгэлээр 100 хувь хяналтыг гүйцэтгэсэн байгаа боловч дотоод хяналт хангалтгүй байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/25 дугаар тушаалаар баталсан ч хангалтгүй ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бүрэн бэлтгээгүй байна.

“Булган АЗЗА” ТӨХК нь 2019 оны Зам, тээврийн хөгжлийн яамны авто замын салбарын “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тухайн НББ-ын бодлогын баримт бичгийг Зам, тээврийн хөгжлийн яамны сайдын тушаалаар батлуулаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Булган АЗЗА” ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 73.4 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6.20	2.32	-3.88
Авлага	571.57	362.25	-209.32
Бараа материал	206.23	379.59	173.36
Үндсэн хөрөнгө	1,176.77	1,143.18	-33.59
Нийт хөрөнгө	1,960.77	1,887.34	-73.43
Өр төлбөр	890.95	1,011.55	120.60
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,069.82	875.79	-194.03
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,960.77	1,887.34	-73.43

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

“Булган АЗЗА” ТӨХК 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 744.2 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, 1,143.8 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй нийт хөрөнгийн хэмжээ 1,887.3 сая төгрөг байна.

Авлага

Тайлант оны эцэст нийт авлагын дүн 362,250.1 мянган төгрөг болж өмнөх оноос 209.3 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны орон нутгийн замын сангийн сангаас 275.0 сая төгрөгийн авлага барагдсантай холбоотой байна.

Авлагын үлдэгдэлд Асгат өргөө ХХК-ийн 32.2, асфальт бетон зуурмаг борлуулсны орлого Д.Энхээгийн 44.6, иргэн Н.Өлзийсайханаас 42.8 сая, Х.Уламбаяраас 33.4, Гэрэлмаагаас 35.0, Н.Отгон-Очироос автомашин шатаасны төлбөр 12.8 төгрөгийн авлагууд 55 хувийг, 45 хувь өмнөх оны авлага эзэлж байна.

Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 379.5 сая төгрөг болж 173.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан бараа материал буюу сэлбэг хэрэгслийг зарцуулаагүй, үнийн өсөлттэй холбоотой байна.

Бараа материал дансны тодруулга хангалтгүй, нярав солигдох үед бараа материалыг нярав хооронд шилжүүлснээс ерөнхий журналд орлого, зарлага давхар бичигддэг, үлдэгдлийг олон төрлөөр салгаж гаргаж байгаа нь ойлгомжгүй, аудитын явцад хүндрэл учруулж байлаа.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн данс тайлант оны эцэст 1,143.8 төгрөг болж 33.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 113.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсан, 12.8 сая төгрөгийн шатсан цаашид ашиглах боломжгүй авто машиныг шүүхийн шийдвэр болон өмнөх аудитын албан шаардлагын дагуу данснаас хасаж 80.0 сая төгрөгийн экскаваторыг өр төлбөрт авсан нь нөлөөлжээ.

Жилийн эцэст өмнөх онд Зам, тээврийн хөгжлийн яамнаас хүлээлгэж өгсөн усны МАЗ /3505/, нөхөөсний БИС /310М/ маркийн тусгай зориулалтын

автомашинууд нь тооллогын бүртгэлд байгаа ч үнэ тодорхойгүй шалтгаанаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгагдаагүй байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөөс шилжүүлсэн болон акталсан хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр

Өр төлбөрийн дансны жилийн эцсийн үлдэгдэлд богино хугацаат өглөг 284.8 сая төгрөг, урт хугацаат өглөг 726.6 сая төгрөг тус тус эзэлж байна.

Богино хугацаат өглөг тайлант оны эцэст 284.8 сая төгрөг болж 119.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Өглөг нэмэгдсэн нь Алсын зам транс ХХК-с худалдан авсан давсны мөнгө 30.8, Жавхлан харгуй ХХК-с асфальтобетон зуурмаг худалдан авсны үлдэгдэл төлбөр 39.5, Цэнгэлийн зүг ХХК-с мастик, замын хуулга 53.3 сая төгрөгөөр тус тус худалдан авч өглөг үүсгэсэн нь нөлөөлсөн байна.

Мөн 2009 онд Зам тээврийн яамны тушаал,ТӨХ-ны тогтоолоор Кувейтын сангийн зээлээр бэлтгэсэн 17 нэр төрлийн машин тоног төхөөрөмжийн 565.1 сая төгрөгийн урт хугацаат зээл дансанд бүртгэлтэй, одоо болтол шийдэгдээгүй байна.

Хуримтлагдсан ашиг 974.5 сая төгрөгийн алдагдалтай тайлант онд 8.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 585 тоот тогтоолоор 2023 оны оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2023 он		Зөрүү	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувиар	Дүнгээр
Нийт орлого	1,950.00	1,573.76	80.7	(376.24)
Үүнээс: Улсын чанартай ЗЗА	1,650.00	1,350.70	81.9	(299.30)
Бусад	300.00	223.06	74.4	(76.94)
Нийт зардал	1,929.55	1,565.14	81.1	(364.41)
Үүгээс:Удирдлагын зардал	334.10	292.50	87.5	(41.60)
Татварын өмнөх ашиг	20.45	8.63	42.2	(11.82)
Цэвэр ашиг/ алдагдал/	18.41	7.76	42.2	(10.64)
Төрийн өмчийн ноогдол ашиг	4.90	-	-	(4.90)
Ажиллагсдын тоо	0.00	0.00	71.1	(0.00)
Цалингийн сан	536.39	543.44	101.3	7.04
Нэг ажилтны дундаж цалин	0.99	1.42	142.5	0.42
Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	0.00	0.00	100.5	0.00
Хөрөнгө оруулалт	85.00	-	-	(85.00)
Нийт авлага	180.00	362.12	201.2	182.12
Нийт өглөг	685.21	1,010.22	147.4	325.01
Үүнээс: Богино хугацаат	120.00	445.01	370.8	325.01
Урт хугацаат өглөг	565.21	565.21	100	-

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Булган АЗЗА” ТӨХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний

төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 585 тоот тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 1,950,0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,929.5 сая төгрөгөөр, 20.4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 85.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 1,573.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,565.1 сая төгрөгийн зардал гарган, 8.6 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,573.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 376.2 сая төгрөг буюу 19.3 хувиар тасарсан нь Зам тээврийн хөгжлийн яамнаас ажилын тоо хэмжээг бууруулж өгсөнөөс шалтгаалжээ.

Нийт зардалын гүйцэтгэл 1,565.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 364.4 сая төгрөг буюу 18.9 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь мөн л яамнаас ажлын тоо хэмжээг бууруулж өгсөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 1 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 85.0 сая төгрөгийн зардлыг төлөвлөсөн нь хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.

Тайлант онд цэвэр ашиг 8.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 11.8 сая төгрөгөөр дутуу байгаа нь төлөвлөсөн орлого буурсан нь нөлөөлжээ.

ТӨБЗГ-с тайлант онд ногдол ашгийг хуваарлаагүй байна.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Булган АЗЗА” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх ТӨХК-ийн түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн тухайн үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

“Булган АЗЗА” ТӨХК 2023 оны санхүүгийн тайлангаа Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын тайлангийн нийт зардал 2,084.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 31.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” А-1/947 албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх чиглэл өгчээ.

Тус ТӨХК нь албан хэрэгцээнд 00-27бул дугаартай ниссан патрол, 93-24буа дугаартай донг гэсэн 2 авто тээврийн хэрэгсэл ашиглаж байгаа бөгөөд жолоочийн цалингийн зардалд 49.2, шатахууны зардалд 16.2, засвар үйлчилгээний зардалд 6.2 нийт 71.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4-т заасны дагуу авто тээврийн хэрэгслийн дугаарын дэвсгэр өнгийг цэнхэр өнгөөр сольсон бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 6.3 дахь заалтууд хамааралгүй, 14 дүгээр зүйлд заасан цахим дэлгүүрээс худалдан авалт хийгдээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 14 удаагийн 40.4 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах шийдвэрийг байршуулаагүй Шилэн дансны тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах, өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсарын аудит хийгдээгүй

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон 3.9 сая төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулсан боловч, 75.1 сая төгрөгийн 2 зөвлөмж, 802.4 сая төгрөгийн 4 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	3.90	3	3.90	100
Албан шаардлага	5	815.40	1	12.80	25
Зөвлөмж	3	75.11	1	0	33
Нийт дүн	11	894.41	5	16.7	158

Өмнөх оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг 52.6 хувь буюу хангалтгүй биелүүлэн ажилласан зөрчилд хариуцлага тооцох албан шаардлагыг харьяалах дээд байгууллагад хүргүүллээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зам, тээврийн хөгжлийн яамнаас хүлээлгэж өгсөн усны МАЗ /3505/, нөхөөсний БИС /310М/ маркийн тусгай зориулалтын автомашинууд нь тооллогын бүртгэлд байгаа ч үнэ тодорхойгүй шалтгаанаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлд одоог хүртэл тусгагдаагүй байгааг харьяалах дээд байгууллагад уламжлан үнийг тодорхойлох арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 65.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залруулах хүсэлтийг тус ТӨХК ирүүлээгүй бөгөөд 65.8 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлээ.

Залруулаагүй алдаа:

Нийт борлуулалтын орлогыг алдаатай тайлагнаж татварын өмнөх ашгийг илүү тооцоолсон. Үүнд:Өмнөх онд хүлээн зөвшөөрсөн 75.9 сая төгрөгийн Бугат сумын ОНХС-гаар хийгдсэн замын ажлыг тайлант онд дахин хүлээн зөвшөөрсөн, тайлант онд асфальт үйлдвэрлэж "Алист констракшин" ХХК-д борлуулсан асфальтын 40 хувь буюу 72.6 сая төгрөгийг, Булган нисэхийн талбай засварлахад зориулж усны машин индүү түрээсэлсний төлбөр 4.8 сая төгрөгийг, Хутаг-Өндөр сумын ЗДТГ эвдрэлд орсон зам талбайг зассан ажлын төлбөр 6.5 сая төгрөг буюу нийт 83.9 сая төгрөгийн орлогыг шатахуунаар хүлээн авсан боловч борлуулалтын орлогод тусгаагүй нь санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 560.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 37.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 360.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 162.91 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Үүнээс өмнөх оны зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй, тайлант онд давтан гаргасан зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Ахмадын баяраар согтууруулах ундаа худалдан авахад 0.04 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1, 15.1.7-д гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

2. Тайлан хугацаанд нийт 1.35 сая төгрөгийн урьдчилгаа цалинг суутгаагүй, санхүүгийн тайлант авлагаар бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 26.1, НББ-ийн тухай хуулийн 20.2.5 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

¹Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

²Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Анхан шатны баримтгүй буюу ажил гүйцэтгэх, бараа нийлүүлэх гэрээ байхгүйгээр иргэн Д.Гэрэлтуяа руу 35.0 сая төгрөгийг тайланд онд шилжүүлэн хий авлага үүсгэсэн ба 2024 оны 03 сард 25.0 сая төгрөгийг байгууллагын харилцах дансанд төвлөрүүлж, 10.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4 дэх заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

4. Иргэн Х.Уламбаяртай асфальт зуурах гэрээ байгуулж ажлын хөлсийг 7.3 сая төгрөгийг илүү тооцон олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 20.1.4 дэх заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

5. Инженер Нямдаваад заводын моторын үнэ гэх 4.0 сая төгрөгийг шилжүүлж хий авлага үүсгэн, моторыг худалдан авалгүйгээр өглөг үүсгэн хаасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4 дэх заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

6. Иргэн Х.Уламбаяр луу гэрээ байгуулаагүй, анхан шатны баримтгүй, НӨАТ-ын И-баримтгүй, тенийн үнэ гэх 2 удаагийн нийт 8.0 сая төгрөгийн гүйлгээг хийсэн, тухай хөрөнгийг хүлээн авч бараа материалын тайланд орлогоор бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4 дэх заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

7. Иргэн Х.Уламбаяр луу гэрээ байгуулаагүй, анхан шатны баримтгүй, НӨАТ-ын И-баримтгүй, ажилласан маслоны үнэ гэх 4.0 сая төгрөгийн гүйлгээг хийсэн, тухай хөрөнгийг хүлээн авч бараа материалын тайланд орлогоор бүртгээгүй, жилийн эцэст тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4 дэх заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн..

8. Захирал албан бус хэрэгцээнд 0.105 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4 дэх заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

9. Инженер Мөнх-Эрдэм нь төгрөгийг 0.18 сая төгрөгийг шатахууныг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

10. Тайлант онд 1.9 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

5.2 Албан шаардлага

1. Тайлант онд Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсан 73.5 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авах, 980 км замын тэмдэг тэмдэглэгээ, будгийн 54.3 сая төгрөгийн төсөвт, өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэхэд тендер зарлаагүй, шууд худалдан

авалт, шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10.2, 10.12, 31.1 дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант онд автомашин, механизмын сэлбэг, материалыг техникийн комисс, өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэлгүйгээр худалдан авсан бөгөөд худалдан авсан сэлбэг хэрэгслээс хэрэглэгдээгүй сэлбэгийн үлдэгдэл нь 36.8 хувь буюу 30.7 сая төгрөг байгаа нь Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.2.2, 2.2.3, 2.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6 дэх гэж заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

3. Тайлант хугацаанд шинээр үүссэн авлага, өглөгийн эцсийн үлдэгдэл 201.9 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн иж бүрдлийг бүрэн хангаагүй буюу Бараа материалын тодруулга, үндсэн хөрөнгийн тодруулгыг ирүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн 8.1.5 дахь заалт болон санхүүгийн тайлангийн аудитын толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн дагуу Төрийн аудитын байгууллагад Санхүүгийн тайлан ирүүлэхдээ санхүүгийн тайлангийн иж бүрэн байдлыг НББ-ийн тухай хуулийн 8.1.5 дахь заалтын дагуу ирүүлэх.

2. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус ТӨХК нь санхүүгийн тайлангийн "Макс" программ ашигладаг бөгөөд тухай программ нь НББОУС, тус байгууллагын НБББББ-т нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн программыг холбогдох хууль, дүрэмд нийцүүлэн хөгжүүлэх.

3. Борлуулалтын орлого

Илрүүлэлт: Нийт борлуулалтын орлого болон татварын өмнөх ашгийг илүү тооцоолон тайлагнасан. Үүнд: Өмнөх онд хүлээн зөвшөөрсөн 75.9 сая төгрөгийн Бугат сумын ОНХС-гаар хийгдсэн замын ажлыг тайлант онд дахин хүлээн зөвшөөрсөн, тайлант онд асфальт үйлдвэрлэж "Алист констракшин" ХХК-д борлуулсан асфальтын 40 хувь буюу 72.6 сая төгрөгийг, Булган нисэхийн талбай засварлахад зориулж усны машин индүү түрээсэлсний төлбөр 4.8 сая төгрөгийг, Хутаг-Өндөр сумын ЗДТГ эвдрэлд орсон зам талбайг зассан ажлын төлбөр 6.5 сая төгрөг буюу нийт 83.9 сая төгрөгийн орлогыг шатахуунаар хүлээн авсан боловч борлуулалтын орлогод тусгаагүй нь санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах

4. Үндсэн хөрөнгө

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлийн зардлаа нөхсөн 0.0 үлдэгдэлтэй үндсэн хөрөнгө нийт үндсэн хөрөнгийн 39.11 хувийг эзэлж байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх зааврыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

5. Илрүүлэлт: Гэрээ байгуулан гүйцэтгэсэн ажил, худалдан авсан бараа материал, сэлбэг хэрэгслийн төлбөр нийт 97,020.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч НӨАТ-ын цахим баримтгүйгээр гүйлгээ хийсэн нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

НӨАТ-ын цахим баримтыг үндэслэн гүйлгээ хийх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийт борлуулалтын орлого, татварын өмнөх ашгийг илүү тооцоолсон.	1	65.8	0	-	1	65.89	0	-	1	65.8	1	65.8
Дүн	-	65.8	-	-	1	65.89	-	-	1	65.8	1	65.8

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/									
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим хуудсанд нийт 29 удаагийн нийт 562,725.3 мянган төгрөгийн таван сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээг мэдээлээгүй.	1	40.40			1	40.4			

Дүн	1	40.4			1	40.4		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /төрийн хэмнэлтийн тухай хууль/								
Ахмадын баяраар согтууруулах ундаа худалдан авахад 43.0 мянган төгрөгийг зарцуулсан	0	-	1	0.04				
Тайлант онд автомашин, механизмын сэлбэг, материалыг техникийн комисс, өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэлгүйгээр худалдан авсан бөгөөд худалдан авсан сэлбэг хэрэгслээс хэрэглэгдээгүй сэлбэгийн үлдэгдэл нь 36.8 хувь буюу 30.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй шаардлагагүйгээр их хэмжээгээр сэлбэг хэрэгсэл бэлтгэсэн байна.	1	30.8			1	30.8		
Дүн	1	31	1	0.04	1	31	-	-
Нийт дүн	2	71	1	0	2	71.2	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэн бараа материалын тодруулга, үндсэн хөрөнгийн тодруулгыг ирүүлээгүй	1	-					1	-				
Тайлан хугацаанд нийт 1,350.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалинг суутгаагүй	1	1.35	1	1.35								
Тайлант онд Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсан 73.5 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авах, 980 км замын тэмдэг тэмдэглэгээ, бүдгийн 54.3 сая төгрөгийн төсөвт, өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэхэд тендер зарлаагүй, шууд худалдан авалт, шууд гэрээ байгуулсан.	1	127.80			1.0	127.80						
Анхан шатны баримтгүй буюу ажил гүйцэтгэх, бараа нийлүүлэх гэрээ байхгүйгээр иргэн Д.Гэрэлтуяа руу 35.0 сая төгрөгийг тайланд онд шилжүүлэн хий авлага үүсгэсэн ба 2024 оны 03 сард 25.0 сая төгрөгийг байгууллагын харилцах дансанд төвлөрүүлж, 10.0 төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	1	10.00	1	10.00								
Иргэн Х.Уламбаяртай асфальт зуурах гэрээ байгуулж ажлын хөлсийг 7.35 сая төгрөгийг илүү тооцон олгосон.	1	7.35	1	7.35								
Инженер Нямдаваад заводын моторын үнэ гэх 4.0 сая төгрөгийг шилжүүлж хий авлага үүсгэн, моторыг худалдан авалгүйгээр өглөг үүсгэн хаасан.	1	4.00	1	4.00								

Иргэн Х.Уламбаяр луу гэрээ байгуулаагүй, анхан шатны баримтгүй, НӨАТ-ын И-баримтгүй, тенийн үнэ гэх 2 удаагийн нийт 8.0 сая төгрөгийн гүйлгээг хийсэн, тухай хөрөнгийг хүлээн авч бараа материалын тайланд орлогоор бүртгээгүй байна.	1	8.00	1	8.00								
Иргэн Х.Уламбаяр луу гэрээ байгуулаагүй, анхан шатны баримтгүй, НӨАТ-ын И-баримтгүй, ажилласан маслоны үнэ гэх 4.0 сая төгрөгийн гүйлгээг гүйлгээ хийсэн, тухай хөрөнгийг хүлээн авч бараа материалын тайланд орлогоор бүртгээгүй, жилийн эцэст тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	1	4.00	1	4.00								
Захирал албан бус хэрэгцээнд 105.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан	1	0.15	1	0.15								
Инженер Мөнх-Эрдэм анхан шатны баримтгүйгээр 180,0 мянган төгрөгийг зарцуулсан	1	0.18	1	0.18								
Гэрээ байгуулан гүйцэтгэсэн ажил, худалдан авсан бараа материал, сэлбэг хэрэгслийн төлбөр нийт 97,020.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч НӨАТ-ын цахим баримтаар баталгаажуулахгүй гүйлгээ хийсэн.	1	97.02					1	97.02				
Анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан	1	1.99	1	1.99								
Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд давтан гаргасан.	1	-							1		0	
Бараа материалын тайланг Е тайланд бусад хангамжийн материал дансанд бөөн дүнгээр тайлагнасан.	1	-					1	-				
Санхүүгийн тайлангийн "Макс" программ нь НББОУС, НБББББ-т нийцээгүй байна.	1	-					1	-				
Тайлант онд шинээр үүссэн авлага, өглөгийн эцсийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	201.97			1.0	201.97						
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлийн зардлаа нөхсөн 0.0 үлдэгдэлтэй үндсэн хөрөнгө нийт үндсэн хөрөнгийн 39.11 хувийг эзэлж байна.							1	-				
Дүн	16	463.81	9	37.02	2	329.77	5	97.02	1	0	0	0